



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/582

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, нүүдлийн соёлын хамтын ажиллагааны хүрээнд “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд 45 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчдийг оролцуулан шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Фестивалд оролцох уран бүтээлчдэд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Булган аймаг, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6384010794

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/5.92 дугаар
захирамжийн хавсралт

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцоход шаардагдах төсөө

Д/д	Тээврийн хэрэгслийн төрөл	Шатахууны төрөл	Хэмжих нэгж	Норм	Туулах километр	Үнэ	Нийт үнэ
1.	22 хүний суудалтай автобус	Дизель	л	20	1400	3,480	974,400
2.	Суудлын машин	АИ92	л	10	1400*4	2,520	1,411,200
3.	Фургон	АИ92	л	12	1400	2,520	423,360
4.	Шатахууны зардал /Сайхан/	Дизель	л	15	200	3,480	104,400
5.	Шатахууны зардал /Тэшиг/	Дизель	л	15	500	3,480	261,000
6.	Шатахууны зардал /Орхон/	АИ92	л	12	50	2,520	15,120
7.	Шатахууны зардал /Хутаг-Өндөр/	АИ92	л	12	375	2,520	113,400
8.	Шатахууны зардал /Баян-Агт/	АИ92	л	12	300	2,520	90,720
9.	Ачаа ачих портерын түрээс		ш	2		650,000	1,300,000
10.	Гэр ачих ачааны машины түрээс		ш	1		3,500,000	3,500,000
11.	Хиймэл зүлэг /8 ханатай 2 гэр, 6 ханатай 1 гэрт дэвсэх/		м	40м		45,160	1,806,400
Нийт үнэ						10,000,000	